


ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
1.	Хугацаатай тайлан мэдээнд тавих хяналт /Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан журмын хавсралт/	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас дээд шатны байгууллагад тайлагнах хугацаатай тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу мөрдөж байна. 	100%
2.	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	30 тогтоол, шийдвэрийн 54 заалтын эхний улирлын хэрэгжилтэд, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 49%, хэрэгжилт хангалтгүй байсан бол хагас жилээр 54 тогтоол шийдвэрийн 90 заалт 64,8%, гуравдугаар улиралд 40 тогтоол шийдвэрийн 64 заалт 86.4%, хэрэгжих шатанд байсан. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангах тухай 2024/01, 2024/02, 2024/03 зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар 65 тогтоол, шийдвэрийн 122 заалтын хэрэгжилтэд, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 95 хувь, бүрэн хэрэгжсэн байна.	100%
3.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 бүлэг, 9 зорилт, 11 арга хэмжээ эхний улиралд 47%, хагас жилийн байдлаар 66,25%, гуравдугаар улиралд 2 зорилго, 7 зорилт 8 арга хэмжээ 70%, хяналт шинжилгээ, үнэлгээний 5 шалгуур үзүүлэлт эхний улиралд 44%, хагас жилээр 55%, 2020-2023 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 98%, тодорхой үр дүнд хүрсэн. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 2 зорилт 4 арга хэмжээ хагас жилээр 50%, гуравдугаар улиралд 77,5%, дөрөвдүгээр улиралд 100%, хяналт шинжилгээ, үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт 100%, үр дүнтэй хэрэгжсэн бөгөөд 2021-2024 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 95% тодорхой үр дүнд хүрсэн байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 2 арга хэмжээ эхний улиралд 50%, хагас жилээр 75%, гуравдугаар улиралд 85%, хяналт шинжилгээ,	100%

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
		үнэлгээний 1 шалгуур үзүүлэлт эхний хагас жилд 65%, эрчимжүүлэх шаардлагатай байсан бол гуравдугаар улиралд 85%, жилийн эцэст 100% үр дүнтэй хэрэгжсэн бөгөөд сар бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд нь илгээж тайлагнасан.	
4.	Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс тус дүүргийн хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний тусгасан 5 бүлэг, 9 зорилт 47 арга хэмжээ эхний улиралд 63%, хагас жилд 74%, гуравдугаар улиралд 84%, жилийн эцсийн байдлаар 92%, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 бүлгийн 35 шалгуур үзүүлэлт эхний улиралд 60%, хагас жилээр 34 шалгуур үзүүлэлт 64%, гуравдугаар улиралд 78%, дөрөвдүгээр улиралд 96% тодорхой үр дүнд хүрсэн. Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 3 зорилго, 3 зорилтын 3 арга хэмжээ эхний улиралд 47%, хагас жилээр 63%, гуравдугаар улиралд 73%, дөрөвдүгээр улиралд 83%, хяналт-шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт эхний улиралд 47%, хагас жилээр 63%, гуравдугаар улиралд 73%, дөрөвдүгээр улиралд 93%, 2021-2024 оны 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд дунджаар 90%, мөн тодорхой үр дүнд хүрчээ. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 15 арга хэмжээ эхний хагас жилийн байдлаар 51%, гуравдугаар улиралд 77%, жилийн эцсийн байдлаар 95,7% тодорхой үр дүнд хүрсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт эхний хагас жилээр 43%, жилийн эцсээр 67%, эрчимжүүлэх шаардлагатай бөгөөд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд нь илгээж тайлагнасан.	100%
5.	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлан	Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээ эхний хагас жилд 57,8%, гуравдугаар улиралд 73.5%, жилийн эцсийн байдлаар 87,4%, хяналт шинжилгээ, үнэлгээний 164 шалгуур үзүүлэлт хагас жилийн байдлаар 63%, гуравдугаар улиралд 74%, жилийн эцсийн байдлаар 85%, хэрэгжсэн бөгөөд 4 жилийн хэрэгжилтийг нэгтгэхэд 151 арга хэмжээ болон 164 шалгуур үзүүлэлт тус тус 91%-тай хэрэгжиж тодорхой үр дүнд хүрч дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд тухай бүр танилцуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж, тайлагнасан.	100%

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
6.	Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлангийн 7 бүлэг, 53 зорилт, 121 арга хэмжээний эхний хагас жилийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 55% эрчимжүүлэх шаардлагатай байсан. Үр дүнгүй 4 зорилтын 9 арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангах тухай хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2024/02 дугаар зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. Жилийн эцсийн хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 97%, "Тодорхой үр дүнд хүрсэн".	100%
7.	Хан-Уул дүүрэгт ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланд улирал тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчил гомдлыг бууруулах чиглэлээр давхардсан тоогоор дүүргийн Засаг даргын харьяа давхардсан тоогоор 88 байгууллагад Тамгын газрын 2024 оны 03/214, 03/1661 тоот албан бичгээр хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал дүүрэгт бүртгэгдсэн өргөдөл 10,6%, гомдол 4,6%-иар өссөн хэдий ч хугацаа хэтэрсэн шийдвэрлэлт 43,6%, шийдвэрлэх явцын зөрчил 58,2%-иар тус тус буурсан байна.	100%
8.	Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны явц, гүйцэтгэлд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн 2023 оны гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2024/01 дугаарт зөвлөмжийг 03/214 тоот албан бичгээр хүргүүлж, 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 2024/02 дугаар зөвлөмжийг 03/1661 тоот албан бичгээр хүргүүлэн биелэлтийг тооцон ажилласан. Жилийн эцсийн гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмж боловсруулж байна.	95%
9.	Дүүргийн Засаг даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх Хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	Дүүргийн Засаг даргын хариуцлагын гэрээний 2 бүлэг 10 зорилт, 92 арга хэмжээ эхний хагас жилийн байдлаар 58%, эрчимжүүлэх шаардлагатай байсан. Тайланг 2024 оны 06 дугаар сарын 18-ны 03/1265 тоот албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тайлагнасан. Хэрэгжилт хангалтгүй 20 арга хэмжээг эрчимжүүлэх тухай хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын болон харьяа хэлтсүүдэд 03/1661 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Жилийн эцсийн биелэлтийг нэгтгэхэд 92%-тай хэрэгжиж тодорхой үр дүнд хүрсэн байна.	100%

Д/д	Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлууд	Хэрэгжилт	Биелэлтийн хувь
10.	Нийслэлийн Засаг даргын шуурхай, үүрэг даалгаврын хэрэгжилт	Нийслэл, дүүргийн удирдах ажилтны 21 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн дүүрэгт хамаарах нийт 160 үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тухай бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахимаар тайлагнасан. Тайлант хугацаанд өгөгдсөн 160 үүрэг даалгавар дунджаар 86,5% хэрэгжсэн байна.	100%
11.	Бусад /Цаг үеийн шаардлагаар хийгдэх хяналт шинжилгээ, үнэлгээ/	Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу дүүргийн засаг даргын дэргэдэх 27 байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд засаг даргын тамгын газраас давхардсан дүнгээр нийт 304 арга хэмжээний саналыг тусгуулсан. Монгол улсын ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх 17 арга хэмжээтэй төлөвлөгөөг эхний 5 сарын байдлаар 90%, үр дүнтэй хэрэгжүүлж, биелэлтийг 5 дугаар сарын 10-ны 01/902 тоот албан бичгээр нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт цахимаар илгээж, хугацаанд нь тайлагнасан.	100%
12.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, хүргүүлэх	2024 онд бодлогын баримт бичгийн хэрэгжилт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын 3 зөвлөмжийг давхардсан тоогоор дүүргийн Засаг даргын харьяа давхардсан тоогоор 88 байгууллагад хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан.	100%
БИЕЛЭЛТ			99,6%

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ 3.БУЯНТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Н.АЛДАРМАА